

МОНГОЛ УЛС  
ЁС ЗҮЙН ХОРОО



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН  
ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН  
ЗӨРЧЛИЙН НЭГДСЭН ДҮН, ТӨЛӨВ  
БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 ОН

УЛААНБААТАР ХОТ  
2024

## **АГУУЛГА**

### **ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

#### **НЭГ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

- |   |     |
|---|-----|
| 1.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх бодлого,<br>хууль тогтоомжийн зохицуулалт | - 7 |
| 1.2 Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо                             | - 9 |

#### **ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- |  |      |
|--|------|
| 2.1 Ёс зүйн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа             | - 13 |
| 2.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, хэлэлцүүлэг | - 14 |
| 2.3 Ёс зүйн нөлөөллийн ажил                            | - 18 |

#### **ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ**

- |  |      |
|--|------|
| 3.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг<br>хянан шийдвэрлэх эрх зүйн орчин  | - 20 |
| 3.2 Ёс зүйн гомдол, мэдээлэл, шийдвэрлэлтийн бүртгэл,<br>хяналтын цахим систем   | - 21 |
| 3.3 Ёс зүйн зөрчилд хүлээлгэсэн хариуцлага   | - 25 |
| 3.4 Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн төлөв байдал,<br>шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох<br>туршилтын судалгааны үр дүн | - 30 |

#### **ДӨРӨВ. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- |   |      |
|---|------|
| 4.1 Ёс зүйн хорооны бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал | - 37 |
| 4.2 Гадаад хамтын ажиллагаа                                   | - 39 |

## **ДҮГНЭЛТ**

Хавсралт 1. Ёс зүйн хууль, эрх зүйн товч мэдээлэл

Хавсралт 2. Нэр томъёоны тайлбар

Хавсралт 3. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт

Хавсралт 4. Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны асуулга (Иргэд) - 1

Хавсралт 5. Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны асуулга (Төрийн албан хаагч) - 2

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

Товчлол	Тайлал
АА	Ажлын алба
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЁЗЗБХЦС	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим систем
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУ	Олон улс
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАХ	Төрийн албан хаагч
ТАЦНС	Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем
ТЗ	Төрийн захиргаа
ТЗТТ	Төрийн захиргаа, төрийн тусгай
ТӨ	Төрийн өндөр
ТТ	Төрийн тусгай
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТҮБД	Төрийн үйлчилгээ, бага дунд
ТҮМБ	Төрийн үйлчилгээ, мэргэжлийн боловсрол
ТҮСУ	Төрийн үйлчилгээ, соёл урлаг
ТҮШУ	Төрийн үйлчилгээ, шинжлэх ухаан
ТҮЭМ	Төрийн үйлчилгээ, эрүүл мэнд
УИХ	Улсын Их Хурал
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХНУМТ	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо
ЭМТҮ	Эрүүл мэнд, төрийн үйлчилгээ



## ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил, ангилал, оноор, тоо
- Зураг 2. Хуулийн үйлчлэх хүрээ
- Зураг 3. Хамтран хийх сургалтын хэрэгцээ
- Зураг 4. Ёс зүйн дэд хороо, төрийн байгууллагаар
- Зураг 5. Ёс зүйн дэд хороо, байршлаар, 2024 он
- Зураг 6. Ёс зүйн дэд хороо, салбараар, 2024 он
- Зураг 7. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгосон урамшуулал, сая төгрөг, 2024 он
- Зураг 8. Цахим болон танхимын сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо
- Зураг 9. Цахим сургалт
- Зураг 10. Удирдлагын академийн ёс зүйн сургалт, оноор
- Зураг 11. “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” хэлэлцүүлэг
- Зураг 12. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл
- Зураг 13. Гомдол, мэдээлэлд холбогдсон төрийн албан хаагч, хүйсээр
- Зураг 14. Гомдол, мэдээлэл гаргагч, хувиар
- Зураг 15. Гомдол, мэдээлэл, төрийн албаны ангиллаар, оноор
- Зураг 16. Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээлэл
- Зураг 17. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим систем
- Зураг 18. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
- Зураг 19. Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагч, албан тушаалын төрлөөр
- Зураг 20. Ёс зүйн зөрчил, хүлээлгэсэн хариуцлага, хувиар
- Зураг 21. Ёс зүйн зан төлөвийг сайжруулах чиг хандлага, арга зам
- Зураг 22. Ёс зүйн зөрчлийн нийтлэг шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс
- Зураг 23. Ёс зүйн хорооны бүтцийн бүдүүвч
- Зураг 24. Хуралдаанд хэлэлцсэн асуудал 2024 он
- Зураг 25. Ирсэн өргөдөл, гомдол, хүсэлт
- Хүснэгт 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, аймгаар
- Хүснэгт 2. Гомдол шийдвэрлэлт, хариуцлага хүлээсэн байдал
- Хүснэгт 3. Улсын хэмжээнд ёс зүйн зөрчилд ногдуулсан хариуцлага
- Хүснэгт 4. Ёс зүйн зөрчил, байршил, төрийн албаны ангиллаар
- Хүснэгт 5. Ёс зүйн хорооны хуралдааны тойм

## **ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.14 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.10 дахь хэсэгт тус тус заасны дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын 2024 оны тайланг нэгтгэн боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль, тогтоомжид үндэслэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн тогтоох, тэднийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нийгмийн хэрэгцээ шаардлага бий болсон.

Олон улсад төрийн албан хаагчийн ёс зүйг хуульчилсан, тусгайлсан хөтөлбөр баталж мөрдүүлдэг сайн туршлага ч түгээмэл байна. Тухайлбал, Австрали, АНУ, БНСУ, Их Британи, Герман, Канад, Франц, Швед, Шинэ Зеланд, Сингапур, Турк, Эстони, Япон зэрэг улс төрийн албан хаагчийн ёс зүйг хууль, дүрэм, журмаар журамласнаас АНУ, БНСУ, Герман, Япон гэсэн 4 улс нь төрийн албан хаагчийн ёс зүйг хуульчилсан байна.

Монгол Улсын төрийн албаны хууль, эрх зүйн орчны судалгаа, олон улсын сайн туршлагад үндэслэн Улсын Их Хурлаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль болон бусад хууль, УИХ болон Ёс зүйн хорооноос баталсан тогтоол, дүрэм, журмууд нь төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээлэл, хүлээн авч хянан шийдвэрлэх үйл ажиллагаа болон сургалт, соён гэгээрүүлэх бодлого, үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин, төрийн албан хаагчийн ёс зүйн тогтолцоо бий болох үндэс суурь болсон.

2024 оны мэдээгээр 4239<sup>1</sup> төрийн байгууллагад 2281 ёс зүйн дэд хороо байгуулагдсан нь нийт төрийн байгууллагын 53.8 хувь байна. Ёс зүйн дэд хорооны 1808 буюу 79.3 хувь нь орон нутагт, 473 буюу 20.7 хувь нь нийслэл хотод, нийт 9855 төрийн албан хаагч ёс зүйн дэд хороонд сонгогдон ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх ажлыг 2024 онд идэвхтэй явууллаа.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 209 дүгээр захирамжаар Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, түүнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг Ёс зүйн хороо ахлан ажилласан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд олон талт уулзалт, хэлэлцүүлгийг 95 байгууллагад

---

<sup>1</sup> Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2023 он

зохион байгуулан, иргэн, албан хаагчдаас ирүүлсэн 1008 саналыг тусгаж, өргөн барьснаар Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар батлав.

Өнгөрсөн хугацаанд төрийн төв байгууллага, 21 аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдад хийсэн сургалт, хэлэлцүүлгийн үр дүнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн багц цагийн сургалтын агуулга”-ыг боловсруулж, Ёс зүйн хорооны хуралдаанаар баталлаа.

Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг танхимаар 476 төрийн байгууллагын 26837, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар<sup>2</sup> (цахим сургалтын систем)-ээр 26200 хандалтын эрхээр 49400, сургалтад нийт 76237 хүн хамрагдсан нь төрийн албан хаагчдын 33.6 хувь байна. Энэ нь нийт төрийн албан хаагчдын 3 хүн тутмын нэгд нь хууль, үндэсний хөтөлбөр, УИХ болон Ёс зүйн хорооноос баталсан тогтоол, дүрэм, журмыг хэрэгжүүлэх арга зүйн мэдээлэл хүргэж ажиллалаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шийдвэрлэхэд шаардлагатай зөвлөмж, гарын авлага бэлтгэж, холбогдох албан тушаалтныг мэдээллээр хангаж ажиллав.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар 595 гомдол, мэдээлэл хүлээн авснаас зөрчил тогтоогдсон 322, тогтоогдоогүй 221, үлдсэн 52 гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэхээр судалж байна. Үүнээс Ёс зүйн хороонд 11, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 1, төрийн байгууллагын ёс зүйн дэд хороонд 583 гомдол, мэдээлэл ирсэн.

Төрийн албан хаагчийн үйлдэл, үйл ажиллагаанд гаргасан ёс зүйн гомдол, мэдээллийн 47.5 хувь нь иргэнээс төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд, 40.6 хувь нь төрийн албан хаагчаас төрийн албан хаагчид, 11.9 хувь нь байгууллагынхаа дотоод хяналт, шалгалтаар гаргасан гомдол, мэдээлэл эзэлж байна.

2024 онд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар ирсэн нийт 595 гомдол, мэдээллийн 322-г нь зөрчил тогтоож, дүгнэлт гаргаснаас 314 буюу 97.5 хувьд нь гомдол, мэдээллийн дүгнэлтэд үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтан ёс зүйн хариуцлага хүлээлгэжээ.

“Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн төлөв байдал, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох туршилтын судалгаа”-г хийж, судалгааны үр дүн, тайлан, зөвлөмжийг 2025 оны үйл ажиллагаандаа тусгаж ажиллахаар төлөвлөж байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль, тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн үндсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, тэднийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ард түмний төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, ёс зүйн хэм хэмжээ,

---

<sup>2</sup> Төрийн албан зөвлөлийн 7:4:10 вебинар (цахим сургалт)-ын систем нь 1 удаа 3000 төхөөрөмж холбогдох боломжтой.

шалгуур үзүүлэлтийг төлөвшүүлэхийн тулд 2025 онд хийх том ажил бол 226496 төрийн албан хаагч, 58000 гаруй төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэр, төсөвт байгууллагын албан хаагчдыг оролцуулсан “Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн төлөв байдал, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох суурь судалгаа”-г зохион байгуулж авах нийгмийн хэрэгцээ, шаардлага байна.

“Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн төлөв байдал, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох суурь судалгаа”-ны үр дүнгээр зорилтот салбарын албан хаагчдад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгаа явуулахаас гадна удирдлагын арга хэлбэрийг оновчтой зохион байгуулах, арга зүйн зөвлөмжөөр хангах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад улс орны туршлагыг судлах, сургалтын арга хэлбэр, агуулга, шалгуур үзүүлэлтийг нутагшуулах, сүүлийн үеийн сургалтын техник технологи нэвтрүүлэхэд УИХ, Засгийн газар бодлогоор дэмжиж ажиллах зайлшгүй шаардлага тодорхойлогдоно.

## **НЭГ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**


### **1.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх бодлого, хууль тогтоомжийн зохицуулалт**

Төрийн албаны зөвлөлийн 129 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам” 2010 онд, Засгийн газрын 33 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс дүрэм” 2019 онд тус тус батлагдсан эрх зүйн актаар төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааг зохицуулж ирсэн.

1994, 2002, 2017 онуудад шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ туссан ч төрийн тусгай албан хаагчийн ажил мэргэжлийн онцлогийг харгалзаж ёс зүйн хэм хэмжээг салбарын хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг Засгийн газрын тогтоолоор зохицуулдаг байлаа.

Ингэхдээ хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч 28 байгууллага (Шүүх, Прокурор, Цагдаа, Онцгой байдал, Эрүүл мэнд, Боловсрол, Гааль гэх мэт) нь хууль, тогтоомж, дүрэм, журмаар тухайн салбарын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг харилцан адилгүй тогтоон мөрдөж байв.

Зураг 1. Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил, ангилал, оноор, тоо<sup>3</sup>



Дээрх зургаас харахад 2018 оныг хүртэл төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийг төрийн захиргааны албан хаагчдаар, 2019 онд төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, 2020 онд төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн тусгай албан хаагчдаар ангилан гаргадаг байв. Энэ бүхэн нь Төрийн албаны зөвлөлөөс ёс зүйн зөрчил нь зөвхөн төрийн албаны нэг ангилалд хамаарах асуудал биш төрийн бүх шатны байгууллагыг хамарсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн дүн мэдээг

<sup>3</sup> Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2019, 2020, 2021, 2022, 2023 он



нэгтгэж, шалтгаан үр дагаврыг тодорхойлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөн цар хүрээнд зохион байгуулж ирснийг гэрчлэх тоон үзүүлэлт юм.

УИХ-аас 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 5, 6 дугаар зүйлд зааснаар урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтууд нь төрийн албан дахь сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйт манлайлал, шударга, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэхэд чиглэсэн.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, “Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба” зорилгын хүрээнд 2021-2030 онд “Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийн алба төлөвшинө”, 2031-2040 онд “Төрийн албан хаагчид нийгэмд ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх тогтолцоо бэхэжсэн байна” гэсэн зорилтуудыг тусгасан.

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.5-д “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудад үндэслэн УИХ-аас 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг баталж, хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн нь төрийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх суурь хууль болсон.

Хуулийн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах чиг үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлж байна.

Хуулиар олгосон чиг үүргийн дагуу төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих, нэгдсэн дүн төлөв байдлын тайлан гаргаж, хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл бүрдсэн.

Зураг 2. Хуулийн үйлчлэх хүрээ



Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор УИХ, байнгын хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоол, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоол, “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай” болон “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” зэрэг тогтоолуудыг гаргав.

Хороо хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд дараах шийдвэрүүдийг гарган, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

1. “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлах тухай” 05 дугаар тогтоол
2. “Ёс зүйн хорооны хуралдааны дэг батлах тухай” 07 дугаар тогтоол
3. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол
4. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам” 13 дугаар тогтоол
5. “Ёс зүйн хороо гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх журам” 14 дүгээр тогтоол
6. “Төрийн албан хаагчийн ёс зүйн багц цагийн сургалтын агуулга, сэдэв батлах тухай” 15 дугаар тогтоолыг тус тус батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ёс зүйн хорооны Ажлын албаны дотоод үйл ажиллагаа, хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөө батлах зэрэг нийт 51 тогтоол, дүрэм журам, танилцуулга, чиглэлийг мөрдлөг болгон ажиллаж байна.

## **1.2 Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо**


Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 10, 11, 12, 13 дугаар зүйл, Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам зэрэг хууль, тогтоомжийн хүрээнд ёс зүйн дэд хороодыг төрийн бүх шатны байгууллагуудад байгуулж, тогтолцоо бүрдүүлж, бэхжүүлэх ажлыг хийв. Ингэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Төрийн албаны тухай, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тус тус заасан нийтлэг хэм хэмжээ, шаардлага, холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгож ажилласан.

2024 онд ёс зүйн дэд хороо болон томилох эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, байгууллага салбарын бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх тухай 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар, 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1/91 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллав.

2024 оны 09 дүгээр сараас дэд хороонд зориулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаар гарын авлага боловсруулж, цахим хэлбэрээр 61 дэд хороонд хүргүүлээд байна.

Төрийн төв байгууллага, харьяа газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар, төрийн бус байгууллагуудаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн талаар хамтран сургалт хийх, удирдлага, арга зүйн зөвлөмж авах тухай нийт 31 албан бичиг ирснийг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэж хамтарч ажиллав.

Зураг 3. Хамтран хийх сургалтын хэрэгцээ



Дээрх хүсэлтийн дагуу 25 ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, албан хаагчид болон улсын байцаагч нарыг хамруулсан сургалтыг тус хорооноос зохион байгуулж, сургалтад танхимаар нийт 3050 албан хаагчийг хамруулсан.

Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 74 дүгээр захирамжаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаар ахлуулан 7 гишүүнтэйгээр Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулж, “Ёс зүйн дэд хорооны хуралдааны дэг” болон дэд хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг тусган “Ёс зүйн дэд хорооны 2024-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Зураг 4. Ёс зүйн дэд хороо, төрийн байгууллаар



2024 оны 12 дугаар сарын байдлаар 4239 төрийн байгууллагын 2281 ёс зүйн дэд хороо байгуулагдсан нь нийт төрийн байгууллагын 53.8 хувь байна. Энэ 2,281 ёс зүйн дэд хорооны 1808 буюу 79.3 хувь нь орон нутагт, 473 буюу 20.7 хувь нь нийслэл хотод байгаа бөгөөд 9855 гишүүн сонгогдон ажиллаж байна.

Ёс зүйн дэд хороо хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтад “Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно” гэж заасны дагуу ёс зүйн дэд хороодын 46.7 хувь нь 3 гишүүнтэй, 40.5 хувь нь 5 гишүүнтэй, 12.8 хувь нь 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 5. Ёс зүйн дэд хороо, байршлаар, 2024 он



Зургаас үзэхэд орон нутаг дахь төрийн байгууллагын тоог байгуулагдсан дэд хороодтой харьцуулж үзвэл Баян-Өлгий аймагт хамгийн өндөр буюу 95.0 хувь, Дорнод аймагт хамгийн бага буюу 15.0 хувьтай байна.


Улаанбаатар хотод ажиллаж буй 473 ёс зүйн дэд хорооны 24.7 хувийг 3 гишүүнтэй, 41.0 хувийг 5 гишүүнтэй, 34.2 хувийг 7 гишүүнтэй байгаа бөгөөд тухайн дүүрэг байрлаж буй төрийн байгууллагатай харьцуулахад Баянгол дүүрэгт хамгийн их 74.2 хувь, Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага 26.0 хувьтай байна.

Зураг 6. Ёс зүйн дэд хороо, салбараар, 2024 он



Гүйцэтгэх засаглалын хэмжээнд ёс зүйн дэд хороодыг салбараар үзэхэд Төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо бүрэн байгуулагдсан бол эдийн засаг, санхүү, гааль 88.7 хувьтай, улсын бүртгэл 16.1 хувьтай байна. Хуулийн үйлчлэлд хамаарах бусад төрийн байгууллагуудын дэргэд 49 ёс зүйн дэд хороо байгуулагдан ажиллаж байна.

Зураг 7. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгосон урамшуулал<sup>4</sup> сая төгрөг, 2024 он



Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд 2024 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр 65 байгууллагад нийт 192.6 сая төгрөгийн урамшуулал олгожээ. Төрийн албаны цалингийн нэгдсэн системд “Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилласны урамшуулал” гэсэн нэмэгдлийн цэсийг бий болгож, цаашид олгогдож буй урамшууллын мэдээллийг гаргах, олгож буй урамшууллын хэмжээ нь журамд нийцэж буй эсэх, тухайн дэд хорооны үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй эсэх, урамшуулал олгохгүй байгаа байгууллагыг илрүүлэх, мэдээ тайлангийн үнэн бодит байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

<sup>4</sup> Сангийн яамны Төрийн албаны цалингийн нэгдсэн систем

## **ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **2.1. Ёс зүйн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ”, 11 дүгээр зүйлийн 11.6.1-т “төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2023 оны 209 дүгээр захирамжаар Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, түүнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг ажилласан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Шинэ сэргэлтийн бодлого, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг баримт бичиг хууль, эрх зүйн үндэслэл болгосон.

Үндэсний хөтөлбөрийн төслийг Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 2 дугаар хуралдаан, 04 дүгээр сарын 09-ний өдрийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцэж, 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг бүрэн эхээр нь Улсын Их Хурлын D-Parliament, Ёс зүйн хорооны [www.ec.gov.mn](http://www.ec.gov.mn), Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) зэрэг албан ёсны цахим хуудаст байршуулж төрийн 45 байгууллагаас 489 санал, 7 удаагийн хэлэлцүүлгийн 50 оролцогчоос давхардсан тоогоор нийт 520 гаруй саналыг авч төсөлд нэгтгэн ажиллав.

Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн чуулганы хуралдаанаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцүүлж, батлуулсан.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсантай холбогдуулан 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1/108 тоот албан бичгээр үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийг хууль тогтоомжид нийцүүлэн салбар, байгууллагын бодлого, төлөвлөлтөд санхүү, төсвийн эх үүсвэрийн хамт тусган хэрэгжүүлэх чиглэлийг яам, агентлаг, аймаг, нийслэлийн томилох эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүллээ.

Төрийн албан дахь сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйт манлайлал, шударга, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх бодлогын уялдааг хангах, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор УИХ-ын ээлжит сонгуулиар байгуулагдсан Засгийн газрын дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах санал боловсруулж ажилласан.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх санал боловсруулж, УИХ-ын Ёс зүй, дэгийн байнгын хороо, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллав.

Ингэснээр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.5-т “Төрийн албаны ёс зүйн зарчмуудад үндэслэсэн суурь шалгуур үзүүлэлтийг боловсруулж, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэнэ.”, 4.2.3.12-т “Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүй, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.”, 4.2.3.13-т “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэсэн арга хэмжээ тусгагдаж батлагдсан.

## 2.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, хэлэлцүүлэг

Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, холбогдох хуулийн нэмэлт, өөрчлөлт, дагаж гарах тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, улмаар төрийн албаны шинэтгэл, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, эрх зүйн орчны шинэчлэл, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн зорилго, үйлчлэх хүрээг хөндсөн өргөн цар хүрээтэй сургалт, сурталчилгааны ажлыг 2024 онд амжилттай хийв.

Дээрх ажлын хүрээнд 5 ажлын хэсэг “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, “Ёс зүйн дэд хороодын ажиллах журам” гэсэн сэдвээр 21 аймгийн ЗДТГ, түүний харьяа агентлаг, газар, хэлтсүүдийн төрийн албан хаагч, ёс зүйн дэд хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд оролцсон нийт 9083 хүнийг хамруулсан соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг 2024 оны 02 дугаар сараас 06 дугаар сард зохион байгууллаа.

Хүснэгт 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, аймгаар

№	Аймаг	Оролцогчийн тоо
1	Архангай	250
2	Баян-Өлгий	550
3	Баянхонгор	420
4	Булган	740
5	Говь-Алтай	480
6	Говьсүмбэр	250
7	Дархан-Уул	800
8	Дорноговь	320
9	Дорнод	486
10	Дундговь	350
11	Завхан	450
12	Орхон	1353
13	Өвөрхангай	300


14	Өмнөговь	160
15	Сүхбаатар	410
16	Сэлэнгэ	750
17	Төв	610
18	Увс	200
19	Ховд	350
20	Хөвсгөл	1000
21	Хэнтий	3500
<b>22</b>	<b>Нийт</b>	<b>9083</b>



2024 онд танхимын сургалтаар 256 төрийн болон нутгийн захиргааны байгууллагын нийт 11343 төрийн албан хаагч, ёс зүйн дэд хороодын гишүүдэд төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, хууль, эрх зүйн мэдээлэл хийж ажиллав.

2024 оны 12 дугаар сарын байдлаар 314 ёс зүйн дэд хороо үйл ажиллагааны тайлангаа ирүүлснээс 220 ёс зүйн дэд хороо нь байгууллагынхаа албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийг таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулжээ. Энэхүү 220 ёс зүйн дэд хорооны зохион байгуулсан сургалтад 15494 төрийн албан хаагч хамрагдсан байна.

Зураг 8. Цахим болон танхимын сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо





2024 онд Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар цахим сургалтаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлах, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт төрийн албан хаагчид, эрдэмтэн судлаачид, иргэдээс санал авахад чиглэгдсэн агуулгыг хүргэж ажилласан.

**Зураг 9. Цахим сургалт**

7:4:10 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-ИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Д.БААТАРСАЙХАН: ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ТА ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН НИЙТЛЭГ ҮҮРЭГ, ХОРИЛГОХ ЗҮЙЛСЭЭ САЙТАР СУДЛААРАЙ



7:4:10 СУРГАЛТ "ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ"-ЫН ТАНИЛЦУУЛГА



Зочин: **А.АЛТАНЗҮЛ**  
Хүрээлэн: Хуульчдын ажиллагааны үндэсний төвийн хөтөлбөр

Ёс зүйн хорооноос хийсэн вебнари 6 удаагийн сургалтад 2024 оны 02 дугаар сараас 08 дугаар сар хүртэлх хугацаанд 15000 онлайн эрхээр 19400 төрийн албан хаагч хамрагджээ.



Ёс зүйн хорооноос зарласан “ЁС-той ЗҮЙ-тэй” нөлөөллийн сарын аяны хүрээнд 4 удаагийн вебнари сургалтад төр, орон нутгийн захиргааны байгууллагын 11200 онлайн эрхээр 30000 гаран төрийн албан хаагч оролцсон.




“ЁС-той ЗҮЙ-тэй” нөлөөллийн сарын аяны хүрээнд 4 удаагийн вебнари сургалтад төр, орон нутгийн захиргааны байгууллагын 11200 онлайн эрхээр 30000 гаран төрийн албан хаагч оролцсон.

Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалтыг танхимаар 570 төрийн байгууллагын 26837, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар (цахим сургалтын систем)-ээр 26200 хандалтын эрхээр 49400, нийт 76237 төрийн албан хаагч буюу нийт төрийн албан хаагчдын 33.6 хувь, тодруулбал, төрийн албанд ажиллаж байгаа 3 хүн тутмын нэгд нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоол, дүрэм, журмыг хүргэж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академиас 2020-2024 онд “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх”, “Ёс зүйн менежмент, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь”, “Ёс зүйт манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх” сэдвээр нийт 8914 төрийн албан хаагчид танхимын, 36830 төрийн албан хаагчид цахимаар сургалт явуулав.<sup>5</sup>

<sup>5</sup> Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 онд ирүүлсэн тайлан

Зураг 10. Удирдлагын академийн ёс зүйн сургалт, оноор<sup>6</sup>



“2024 онд улсын хэмжээнд ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалт, соён гэгээрүүлэх ажилд нийт 71512 төрийн албан хаагч хамрагдсан нь өмнөх оноос 44467 буюу 1.6 дахин өссөн үзүүлэлт юм”<sup>7</sup> гэж Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос дүгнэжээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11.6.3-т “төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах”, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилт 2.1.2-д “Төрийн албан хаагч бүрийг ёс зүйн багц цагийн цахим сургалтад жил бүр хамруулж, үр дүнг тооцох ажлыг байгууллага зохион байгуулж, Ёс зүйн дэд хороо арга зүйн заавраар хангана. Ёс зүйн хороо багц цагийн сургалтын агуулга, сэдвийг тогтооно” гэж тус тус заасан.

“Ажил үүргийн хуваарь батлах тухай” А/10 дугаар тушаалын дагуу сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах зорилгоор Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо, Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” хэлэлцүүлгийг УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын эрх бүхий албан тушаалтан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ХЗДХЯ, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар, тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг агентлагийн дарга нар, яамдын ёс зүйн дэд хороодын төлөөлөл, их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдыг оролцуулан 2 удаа зохион байгуулж санал авч тусгав.

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> Мөн тэнд

## Зураг 11. “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” хэлэлцүүлэг



2024 оны 10 дугаар сарын 15

“Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” эхний хэлэлцүүлэг, оролцогч 55 хүн

Чингис хаан Үндэсний музей, Хурлын танхим

2024 оны 11 дүгээр сарын 15

“Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” Хоёр дах хэлэлцүүлэг, оролцогч 89 хүн

Хууль зүй, дотоод хэргийн яам  
Хурлын танхим



“Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” сэдэвт 2 шатны хэлэлцүүлгийн үр дүнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтын дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүйн багц цагийн сургалтын агуулга”-ыг боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хорооны 14 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж 15 дугаар тогтоолоор батлуулсан нь 2024 оны онцлох ажлуудын нэг болсон.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн багц цагийн сургалтын агуулга”-ыг боловсруулсан үндсэн зорилго нь төрийн ажил, чиг үүргийг үнэт зүйл, зарчимд суурилан гүйцэтгэх мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор төрийн байгууллага бие даан зохион байгуулах сургалтын агуулга, багц цаг, хөтөлбөрийг гаргаж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ.

### 2.3. Ёс зүйн нөлөөллийн ажил

Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороонд байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, Ёс зүйн дэд хорооны журмыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх зөвлөмж, гарын авлага бэлтгэж, холбогдох албан тушаалтныг мэдээллээр хангаж ажиллав.

Ёс зүйн дэд хороо, эрх бүхий албан тушаалтны чиг үүргээ хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар нэгдмэл ойлголт өгч, арга зүйгээр хангахын зэрэгцээ төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах зарчим, харилцаа хандлага, ёс зүйн хариуцлагын төрөл зэрэг сэдвээр сургалт, уулзалтыг зохион байгуулав.





Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах чиг үүргийн хүрээнд тус хорооноос баталсан 2024 оны 10, 13 дугаар тогтоолыг, 2024 оны 4/119 дугаар албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг дарга, 2024 оны 4/120 дугаар албан бичгээр Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус хүргүүлж ажиллав.

2024 оны 11 дүгээр сарыг “ЁС-той ЗҮЙ-тэй” нөлөөллийн аян болгон зарласан. Нөлөөллийн сарын аяны хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар цахим



сургалтын платформоор “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд”, “Төрийн албан хаагчийн ёс зүй (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх)”, “Дижитал ёс зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй: Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа” гэсэн 4 үндсэн сэдвээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн талаар төрөөс баримталж буй бодлого, хэрэгжилт, анхаарах асуудлын талаар чиглэл өгч, зохион байгуулав.

“ЁС-той ЗҮЙ-тэй” нөлөөллийн сарын аяны хүрээнд 235 төрийн байгууллагын 2260 төрийн албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд”, “Төрийн албан хаагчийн ёс зүй: Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа”, “Төрийн албан хаагчийн ёс зүй (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх)” гэсэн сэдвээр мэдээлэл түгээв.

2281 ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл, арга зүйн зөвлөгөө өгсний үр дүнд санал санаачилга гарган ажиллаж байгаа Ёс зүйн дэд хороод, хэрэгжүүлсэн онцлох ажлыг дурдах нь зүйтэй. Үүнд:

-  Хариуцсан салбар, байгууллагад ёс зүйн зөрчил гарч байгаа болон үүсч болзошгүй эрсдэлд дүн шинжилгээ хийсэн, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа хэрэгжүүлсэн - 60
-  Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм, журмыг таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан - 220
-  Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн - 84
-  Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр салбарын хэмжээний бодлого төлөвлөлтөд тусгасан - 89

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн Долоодугаар бүлгийн 19 дүгээр зүйлд 19.1-т зааснаар ёс зүйн дэд хороод дараа оны 01 дүгээр сард тайлангаа Ёс зүйн хороонд ирүүлэхээр хуульчилсан. Ёс зүйн дэд хорооны гаргасан санаачилгатай ажлаас онцлох заримыг нь дурдвал:

-  Үндэсний аудитын газар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга байдлыг төлөвшүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын ёс зүйн мэдлэг, чадвар, дадлыг гүнзгийрүүлэх зорилгоор 3 кредит, 48 цагийн Төрийн аудиторын ёс зүйн 12 сэдэвт хичээлд 395 албан хаагч хамруулж, албан хаагчдаар ёс зүйн дүрмийг мөрдөх баталгаа гаргуулсан;
-  Гаалийн ерөнхий газар, түүний харьяа газруудад 20 Ёс зүйн дэд хороо ажиллаж байна. Салбарын ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах “Ёс зүйн хөгжлийн чиг хандлага” сэдэвт анхан шатны болон ахисан түвшний сургалтыг хийжээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Ёс зүйн дэд хороод гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэх, дүгнэлтийн загвар”-ыг гарган ашигласан;



- 👍 Гадаадын иргэн харьяатын газар “Удирдах ажилтны ёс зүй”, “Ёс зүйгээр байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь”, “Үнэт зүйл, ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтууд зохион байгуулсан;
- 👍 Онцгой байдлын байгууллагын ёс зүйн зөвлөгөөн 2024.11.04-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад албан хаагчдын гэр бүлийг давхар хамруулсан;
- 👍 Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газраас 2024 оны эхний 10 сарын байдлаар алба хаагчийн аюулгүй байдал, сахилга, хариуцлага, эрүүл мэнд, сэтгэл зүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын болон алба хаагчдыг чадавхжуулах чиглэлээр 16 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 11646 алба хаагч, ажилтан оролцсон;
- 👍 Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь ажиллагсдын эрхэмлэн ажиллах “Гурван З, Гурван Х-ийн” зарчмыг боловсруулан баталж хэрэгжүүлснээр ажилтан бүр бие биедээ зөвлөн халамжлах, зөвшилцөл, хамтын ажиллагаа, зөв харилцааг эрхэмлэн ажиллаж хэмлэн буруутгах, хов ярих, хэрүүл маргаанаас ангид байж хамтын хүчээр ажиллаж хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэв. “СЭТГЭЛЭЭ ЖОЛООДОЖ-ХҮНДЛЭЛИЙГ ТҮГЭЭЭ” аян, Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах заавар гарган ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэн ажилласан;
- 👍 Цагааннуур чөлөөт бүс нь байгууллагын албан хаагч, ажилчдын уур амьсгалыг сайжруулах зорилгоор "Миний сэтгэлийн илгээмж" захидлын аян өрнүүлсэн;
- 👍 Сэлэнгэ аймгийн ЗДТГ “Мэндлэх хүндлэх ёс, харилцаа хандлага” сэдэвт сургалт зохион байгуулж, өмнө ажиллаж байсан байгууллагаасаа ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх тодорхойлолт авч эхэлсэн;
- 👍 Дундговь аймгийн ЗДТГ "Дипломат сар" аяныг зохион байгуулж, “Бие биедээ талархал илэрхийлэх сар” шуудангийн хайрцаг, Ёс зүйн санамж гаргаж албан хаагчдад түгээсэн зэрэг өөрийн байгууллагын онцлогт тохирсон арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлжээ.

## **ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН НЭГДСЭН ДҮН, ТӨЛӨВ БАЙДАЛ**

### **3.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн үйлчлэлд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3 дахь “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан”, 4.1.4 дэх “олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал”, 4.1.5 дахь “улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан”, 4.1.7 дахь “бүх шатны

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч”, 4.1.9 дэх “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн” хамаарна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн албан хаагчийн сахин мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг, 8 дугаар зүйлд төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлагыг нийтлэг үүрэг болон хориглох үйл ажиллагааг тусгасан. Тухайн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Ёс зүйн хорооны, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна” гэж хуульчилсан.

Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-т заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалт болон бусад хориглох үйл ажиллагааг тусгаж өгсөн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11, 13 дугаар зүйлд Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах бүрэн эрхтэй гэж заасан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөмж өгөх, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн дагуу Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-аар ёс зүйн мэдээллийн цахим сангийн бүрдлийн жагсаалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэлийн маягтыг батлан мөрдүүлж байна.

Журмын хэрэгжилтийг хангаснаар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авах, түүний шийдвэрлэлтийг бүртгэх, хяналтын цахим сан бүрдүүлэх, үйл ажиллагааг тайлагнах, олон нийтэд мэдээлэх ач холбогдолтой юм.

Төрийн 4239 байгууллагад ажиллаж буй 226496 төрийн албан хаагчийн гомдол, мэдээлэлд холбогдсон, ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн болон сайн дураараа хариуцлага хүлээсэн албан хаагчдын нэгдсэн бүртгэлийг хөтлөх, улмаар ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зорилтот бүлэгт чиглүүлж оновчтой хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

### 3.2. Ёс зүйн гомдол, мэдээлэл, шийдвэрлэлтийн бүртгэл, хяналтын цахим систем

Улсын хэмжээнд нийт гомдол, мэдээллийн тоо 755, үүнээс гэмт хэргийн шинжтэй 4, сахилгын шинжтэй 106, зөрчлийн шинжтэй 50, ёс зүйн зөрчилтэй холбоотой 595 тус тус бүртгэгдсэн.

Ёс зүйн хороо, Засгийн газрын дэргэдэх ёс зүйн хороо болон төрийн байгууллагуудын дэргэдэх ёс зүйн дэд хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар 595 гомдол, мэдээлэл хүлээн авснаас зөрчил тогтоогдсон 322, зөрчил тогтоогдоогүй 221, хянан шалгах ажиллагаанд 52 гомдол, мэдээлэл байна.

Зураг 12. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл



Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тоо бүртгэлээр 226496<sup>8</sup> төрийн албан хаагчийн хүйсийн харьцаа 63.7 хувь нь эмэгтэй, 36.3 хувь нь эрэгтэй байгаа бол 595 ёс зүйн гомдол, мэдээлэлд дурдагдсан 600 албан хаагчийн 333 нь буюу 55.5 хувь нь эмэгтэй, 267 буюу 44.5 хувь нь эрэгтэй албан хаагч байна.

Харин төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын хүйсийн харьцааг нь тэдний хүйсийн эх олонлогт харьцуулан жигнэж үзвэл эрэгтэй төрийн албан хаагчийн 58.4 хувь, эмэгтэй төрийн албан хаагчийн 41.6 хувь ёс зүйн зөрчилд холбогджээ.

Зураг 13. Гомдол мэдээлэлд холбогдсон төрийн албан хаагч, хүйсээр



<sup>8</sup> Төрийн албаны зөвлөлийн 2023 оны жилийн эцсийн статистик. Төрийн албан хаагчийн тоо жилд нэг удаа жилийн эцсээр гардаг болно.

Зураг 14. Гомдол, мэдээлэл гаргагч, хувиар




Төрийн албан хаагчийн үйлдэл, үйл ажиллагаанд гаргасан ёс зүйн гомдол, мэдээллийн 47.5 хувь нь иргэнээс төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд, 40.6 хувь нь төрийн албан хаагчаас төрийн албан хаагчдаа, 11.9 хувь нь байгууллагын дотоод хяналт, шалгалтаар илэрсэн ёс зүйн зөрчил байна.

Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төрийн байгууллагын албан хаагчдад багаар ажиллах, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй хандах чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

Гомдол, мэдээлэлд холбогдогчдын 8.3 хувь нь төрийн улс төрийн, 38.3 хувь нь төрийн захиргаа, 10.0 хувь нь төрийн тусгай, 39.4 хувь нь төрийн үйлчилгээ, хуулийн 14.3.1, 14.3.2-т зааснаас бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан 4.0 хувийг эзэлж байна.

Зураг 15. Гомдол, мэдээлэл, төрийн албаны ангиллаар, оноор



Өмнөх 5 жилийн дунджаар жилд 495 албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж байсан бол 2024 онд 600 болж өссөн нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14.3



дахь заалтын дагуу ёс зүйн зөрчил гаргасан төрийн улс төр, төрийн тусгай ангилал болон хуульд заасан бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтныг нэмж бүртгэдэг болсонтой холбоотой.

Үүнээс Ёс зүйн хороонд 2024 онд 60 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс 40 нь төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл байгаа бөгөөд үүний 1 (2.5%) нь зөрчил тогтоогдож, 29 (72.5%) нь харьяалах ёс зүйн дэд хороонд шилжүүлж, 10 (25.0%) нь шийдвэрлэх шатандаа байна.


Зураг 16. Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээлэл



Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтантай холбоотой 1 гомдол, мэдээлэл ирүүлснийг шийдвэрлэхээр хянан шалгаж байна.

Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд дэд систем байдлаар хөгжүүлж Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системийг <https://www.hrm.csc.gov.mn> холбоосоор 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс нэвтрүүлсэн.

Зураг 17. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим систем



Ёс зүйн бүртгэл, хяналтын цахим систем нэвтэрснээр улсын хэмжээний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, гомдол мэдээллийн нэгдсэн тайлан гаргах, шийдвэрлэлтэд хяналт тавих, холбогдох талуудыг мэдээллээр хангах боломж бүрдэж байна.

Ёс зүйн хорооны үйл ажиллагааг тусгасан төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS 6285-2027 Монгол Улсын стандартыг хангасан, төрийн мэдээллийн бусад системтэй холбож ашиглах техникийн шийдэл бүхий, дизайн, удирдлагын оновчтой, шийдэлтэй албан ёсны [www.ес.gov.mn](http://www.ес.gov.mn) цахим хуудсыг 2024 оны 06 дугаар сараас эхлэн нэвтрүүлсэн. Албан ёсны цахим хуудсаар хорооны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар хүргэх, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

### 3.3. Ёс зүйн зөрчилд хүлээлгэсэн хариуцлага

Ёс зүйн хороо болон дэд хороодын дүгнэлтээр 322 зөрчил тогтоогдсоноос томилох эрх бүхий албан тушаалтан 314 буюу 97.5 хувьд ёс зүйн хариуцлага хүлээлгэж, 8 зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байна.

Зураг 18. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Ёс зүйн зөрчил нь тогтоогдож, хуулийн дагуу дүгнэлт нь гарсан 314 төрийн албан хаагчийн 274 албан хаагч нь “томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр”, 40 албан хаагч нь “ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн” байна.

Мөн ёс зүйн хариуцлага хүлээсэн албан хаагчдыг албан тушаалын төрлөөр авч үзэхэд удирдах 24 (7.6%), гүйцэтгэх 241 (76.8%), туслах 49 (15.6%) байна.

Зураг 19. Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагч, албан тушаалын төрлөөр


**Хүснэгт 2. Гомдол шийдвэрлэлт, хариуцлага хүлээсэн байдал**

Харьяалах байгууллага	Ирсэн гомдол, мэдээлэл	Ирсэн гомдол, мэдээлэл шийдвэрлэлт		Ёс зүйн хариуцлага хүлээсэн байдал		Хянаж байгаа
		Зөрчил тогтоогдож дүгнэлт гарсан	Зөрчил тогтоогдоогүй дүгнэлт гарсан	Томилох эрх бүхий албан тушаалтан	Ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн	
Ёс зүйн хороо	11	1	-	-	1	10
Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо	1	-	-	-	-	1
Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо	583	321	221	274	39	41
<b>Дүн</b>	<b>595</b>	<b>322</b>	<b>221</b>	<b>274</b>	<b>40</b>	<b>52</b>

Нийт 595 ёс зүйн гомдол, мэдээллийг хянаж үзэхэд зөрчил тогтоогдсон 322, тогтоогдоогүй 221, шийдвэрлэх шатандаа байгаа 52 байна. Хариуцлага ногдуулсан 314 зөрчлөөс 274 буюу 87.2 хувьд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хариуцлага хүлээлгэсэн, 40 буюу 12.8 хувь нь сайн дураараа ёс зүйн хариуцлага хүлээсэн байна.

**Хүснэгт 3. Улсын хэмжээнд ёс зүйн зөрчилд ногдуулсан хариуцлага**

Харьяалах байгууллага	Ёс зүйн зөрчилд тооцсон дүгнэлт	Ёс зүйн хариуцлага хүлээсэн байдал					
		Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн-259				Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн-55	
		16.1.1. гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;	16.1.2. өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;	16.1.3. байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;	16.1.4. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах.	17.2.1. хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;	17.2.2. ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.
Ёс зүйн хороо	1	-	-	-	-	-	1
Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо	-	-	-	-	-	-	-
Байгууллагын Ёс зүйн дэд хороо	313	79	93	89	13	27	12
<b>Дүн</b>	<b>314</b>	<b>79</b>	<b>93</b>	<b>89</b>	<b>13</b>	<b>27</b>	<b>13</b>

Томилох эрх бүхий албан тушаалтан Ёс зүйн хороо болон Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйл болон 17 дугаар зүйлд заасны дагуу “гомдол гаргагчид, эсхүл хамт олон, олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох” 79, “өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах” 93, “байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах” 89, “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах” 13, ёс зүйн хариуцлага сайн дураараа хүлээн зөвшөөрч “хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх” 27, “өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан” 13, нийт 314 төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэжээ.

Ёс зүйн зөрчлийг төрийн албаны ангиллаар үзэхэд төрийн үйлчилгээ 171 буюу 54.5 хувь, төрийн захиргаа 92 буюу 29.3 хувь, төрийн тусгай 40 буюу 12.7 хувь, төрийн улс төрийн 9 буюу 2.9 хувь, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14.3.3-т заасан төрийн бусад байгууллагын албан тушаалтан 2 буюу 0.6 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 4. Ёс зүйн зөрчил, байршил, төрийн албаны ангиллаар**

Аймаг	Төрийн улс төрийн	Төрийн захиргааны	Төрийн тусгай	Төрийн үйлчилгээний	Төрийн болон ОН өмчит	Нийт
Архангай	1	1	-	20		22
Баян-Өлгий	-	1	-	-	-	1
Баянхонгор	-	-	-	5	-	5
Булган	-	6	-	6	-	12
Говь-Алтай	-	2	-	3	-	5
Говьсүмбэр	-	-	-	-	-	-
Дархан-Уул	-	-	-	-	-	-
Дорноговь	-	3	-	2	-	5
Дорнод	-	1	-	2	-	3
Дундговь	-	3	-	8	-	11
Завхан	-	2	-	2	-	4
Орхон	-	3	-	5	-	8
Өвөрхангай	1	1	-	18	-	20
Өмнөговь	-	1	-	2	-	3
Сүхбаатар	-	-	-	1	-	1
Сэлэнгэ	-	2	-	4	-	6
Төв	1	3	2	22	-	28
Увс	-	1	-	6	-	7
Ховд	-	2	-	7	-	9
Хөвсгөл	-	3	-	2	-	5
Хэнтий	-	-	-	9	1	10
Улаанбаатар	6	57	38	47	1	149
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>92</b>	<b>40</b>	<b>171</b>	<b>2</b>	<b>314</b>

Ёс зүйн зөрчлийг байршил, төрийн албаны ангиллаар үзэхэд Төв аймаг 28 буюу 8.9 хувь, Баян-Өлгий, Сүхбаатар аймагт тус бүр 1 буюу 0.3 хувийг эзэлж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн 314 зөрчлийн 79.0 хувь нь хуулийн 8.1-д заасан нийтлэг үүргээ биелүүлээгүй, 21.0 хувь нь 8.2-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан ёс зүйн зөрчил гаргасан байна.

Зураг 20. Ёс зүйн зөрчил, хүлээлгэсэн хариуцлага, хувиар



Хуулийн 8.1.1-д заасан нийтлэг үүрэг биелүүлээгүй зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүлээлгэсэн хариуцлагыг үзвэл 24.3 хувьд гомдол гаргагч, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох (16.1.1), 32.6 хувьд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах (16.1.2), 30.6 хувьд байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах (16.1.3), 2.1 хувьд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах хариуцлага хүлээлгэсэн бол 7.6 хувь нь хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, олон нийтийн өмнө уучлалт гуйх (17.2.1), 2.8 хувь нь өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх (17.2.2) ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн байна.

Хуулийн 8.1.3-д заасан нийтлэг үүрэг биелүүлээгүй зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүлээлгэсэн хариуцлагыг үзвэл 33.7 хувьд гомдол гаргагч, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох (16.1.1), 27.9 хувьд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах (16.1.2), 17.3 хувьд байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах (16.1.3), 2.9 хувьд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах хариуцлага хүлээлгэсэн бол 14.4 хувь нь хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, олон нийтийн өмнө уучлалт гуйх (17.2.1), 3.8 хувь нь өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх (17.2.2) ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээв.

Хуулийн 8.2.2-д заасан нийтлэг үүрэг биелүүлээгүй зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүлээлгэсэн хариуцлагыг үзвэл 50.0 хувьд байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах (16.1.3), 50.0 хувьд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах хариуцлага хүлээлгэсэн.

Хуулийн 8.2.4-д заасан нийтлэг үүрэг биелүүлээгүй зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүлээлгэсэн хариуцлагыг үзвэл 5.9 хувьд гомдол гаргагч, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох (16.1.1), 11.8 хувьд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах (16.1.2), 70.6 хувьд байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах (16.1.3), 11.8 хувьд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах хариуцлага хүлээлгэсэн.

Хуулийн 8.2.8-д заасан нийтлэг үүрэг биелүүлээгүй зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүлээлгэсэн хариуцлагыг үзвэл 17.0 хувьд гомдол гаргагч, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох (16.1.1), 31.9 хувьд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах (16.1.2), 29.8 хувьд байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах (16.1.3), 8.5 хувьд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах хариуцлага хүлээлгэсэн бол 2.1 хувь нь хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, олон нийтийн өмнө уучлалт гуйх (17.2.1), 10.6 хувь нь өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх (17.2.2) ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн байна.

### **3.4. Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн төлөв байдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох туршилтын судалгааны үр дүн**

Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлийг судалж, зөрчлийн өнөөгийн төлөв байдлыг жил тутам тодорхойлох судалгааны үндэслэл, арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулах чиглэлээр зөвлөх багтай хамтран ажилласан.

Төрийн алба, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт болон энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, онол, арга зүй, олон улсын туршлагыг тоймлон судлах, Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох асуудлаар талуудын төлөөллийг оролцуулсан бүлгийн ярилцлага зохион байгуулах, үр дүнг нэгтгэн боловсруулах судалгааны арга зүй, асуулга удирдамжийг боловсруулсан. /Хавсралт 4, 5-ыг үзнэ үү/

Судалгааны үр дүнгээс дурдвал орчин үеийн ёс зүйн судалгаанууд нь байгууллага, хувь хүний ёс зүйтэй холбоотой практик асуудлуудыг судалж, ёс зүйн зөрчлийн шалтгаан түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, үр дагаврыг шинжлэх, ёс зүйн зан төлөвийг сайжруулах боломжит арга замыг тодорхойлоход төвлөрч байна.

#### **Төрийн албаны ёс зүй, ёс зүйн зөрчлийг судлах онол, арга зүй**

Орчин үеийн төрийн алба, засаглалын тухай үзэл баримтлалуудад ёс зүйг чухал үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэж байна. Төрийн албан хаагчид ёс зүйтэй байх нь нийгмийн итгэл, засаглалын үр дүнтэй шууд холбоотой бөгөөд төрийн байгууллагуудын ил тод, шударга, хариуцлагатай байдлыг баталгаажуулахад чухал ач холбогдолтой ажээ. Иргэдийн амьдралд нөлөөлөх төрийн шийдвэр, бодлого, үйл

ажиллагааны хувьд ёс зүйн стандартыг сахих нь иргэдийн итгэлийг даасан засаглалыг бий болгоход чухал түлхэц болдог (Kettl, 2017) байна.

Төрийн албаны ёс зүй нь албан хаагчдад зөвхөн хууль эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх төдийгүй, тэднийг шударга ёс, ил тод байдал зэрэг ёс суртахууны үнэт зүйлс, зарчмууд, мэргэжлийн ёс зүйд суурилсан үйл ажиллагаа явуулах шаардлагыг тавьдаг. Түүнчлэн төрийн албаны ёс зүй нь улс орны хөгжлийн суурь, нийгмийн шударга байдлыг хангах, хүний эрхийг хамгаалах, төрийн хэрэгжүүлж буй бодлогыг үр дүнтэй, шударгаар хэрэгжүүлэх гол үндэс суурь болж байдаг (Schwartz, 2016) ажээ. Улмаар төрийн байгууллагын чадавхыг, олон нийттэй харилцах чадварыг нэмэгдүүлж, төрийн үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг байна (Robert Denhardt, Janet Denhardt, Tara Blanc, 2013).

Орчин үед төрийн албанд албаны ёс зүй нь төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлага, ёс зүйтэй шийдвэр гаргалт, үйл ажиллагааны ёс зүйт шинж чанарыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Төрийн албан дахь ёс зүйн ач холбогдлыг дараах үндэслэлээр тайлбарлаж болох юм.

**Шударга засаглал, хариуцлагатай төрийн үйл ажиллагаа:** Төрийн албаны ёс зүй нь төрийн бодлого, үйл ажиллагааны үр дүнг зөв хэмжих, шударга байдал, хариуцлагатай үйл ажиллагааг баталгаажуулахад чухал үүрэгтэй. Шийдвэр гаргагчид, төрийн албан хаагчид нийгмийн сайн сайхны төлөө, иргэдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах шаардлагатай байдаг. Үүний зэрэгцээ, шударга засаглал нь хүний эрх, хууль дээдлэх ёсыг хамгаалах үндэс суурь болдог ажээ. Төрийн бодлого, шийдвэрүүд нь иргэдийн амьдралд бодит өөрчлөлт авчрахуйц байж, төрийн албан хаагчид нь ёс зүйн хувьд хариуцлагатай ажиллах ёстой (United Nations, 2015).

**Иргэдийн итгэл, нийгмийн түншлэл:** Иргэдийн итгэл нь төрийн албан хаагчдын хувьд чухал үнэт зүйл бөгөөд ёс зүйгүй, хууль бус, хариуцлагагүй шийдвэр, үйлдэл нь олон нийтийн итгэлийг бууруулж, төрийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг талтай. Төрийн албаны ёс зүй нь энэхүү итгэлийг даах, хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд төрийн үйл ажиллагаанд засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх, хууль дээдлэн ажиллах шаардлагатай болохыг илэрхийлдэг (OECD, 2000).

**Засаглалын ил тод байдал, шударга ёс:** Ёс зүйн зарчим, хэм хэмжээг төрийн албан хаагчид нэгдмэл байдлаар дагаж мөрдөх нь ил тод байдал, зүй зохистой үйл ажиллагааг бий болгоход чухал үүрэгтэй. Энэ нь төрийн албан хаагчдад өөрсдийн шийдвэрүүдийн хариуцлагыг хүлээн зөвшөөрч, шийдвэр гаргалтад нөлөөлөх эрх мэдлийг зөв зохистой ашиглах, ёс зүйтэй шийдвэр гаргахад нөлөөлдөг байна. Төрийн албаны ёс зүйд ил тод байдал, хариуцан тайлагналт, хариуцлага хүлээх чадвар нь үйл ажиллагааны үндсэн зарчмууд болдог (Transparency International, 2020).

**Төрийн албан хаагчдын ёс зүйн мэргэжлийн ур чадвар:** Төрийн албаны ёс зүй нь зөвхөн хэм хэмжээг тогтоох, дүрэм журмыг сахиулах төдий бус, ажил, мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, төрийн албаны нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны шударга, хариуцлагатай, ил тод байдалд чиглэсэн ёс зүйн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох замаар төрийн албаны үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг (Bowman, J. S., West, J. P., 2018).



Ийнхүү төрийн албаны ёс зүй нь зөвхөн төрийн бодлого, үйл ажиллагаа төдийгүй нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх, зөв хэвшил бий болгох, төрийн үүргийг ёс зүйн хариуцлагаар дэмжих чухал суурь болдог ажээ.

Бид энэхүү судалгааны арга зүй, дизайн, аргын сонголтын үндэслэлийг тодорхойлох зорилгоор төрийн албаны ёс зүйг судлах ёс зүйн сонгодог болон орчин үеийн онолуудыг харьцуулан доорх байдлаар авч үзлээ.

### **Ёс зүйн сонгодог онолууд ба төрийн албаны ёс зүйн судалгаа дахь хэрэглээ**

Төрийн албаны ёс зүйн төлөв байдлыг судлах судалгаанд ёс зүйн сонгодог онолууд чухал ач холбогдолтой юм. Энэ нь төрийн албан хаагчдын шийдвэр, үйл ажиллагааны үндсийг илүү ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэжлийн болгоход чиглүүлдэг бөгөөд төрийн үйлчилгээний тэгш хүртээмжтэй, шударга, итгэл төрүүлэхүйц байдлыг дээшлүүлэхэд нөлөөлдөг.

Ёс зүйн сонгодог онолууд нь хүний үйлдлийн зөв, бурууг тодорхойлох олон талт үзэл санааг агуулах бөгөөд ёс суртахууны үндсэн хандлага, шийдвэр гаргалтад нөлөөлдөг. Эдгээр онолууд нь ерөнхийдөө дараах үндсэн чиглэлүүдэд ангилагдаж байна.

#### **1. Зан байдал, сайн чанарын ёс зүйн онол (Virtue Ethics)**

Зан байдал, сайн чанарын ёс зүйн онол нь хүний үйлдлийг бус зан байдлыг сайн, шударга, ёс суртахуунтай байлгах, хүний дотоод зан чанар, хүмүүжил, ёс суртахууны үнэт зүйлсэд төвлөрдөг. Энэхүү онол нь Сократ, Аристотель, Күнз нарын философи үзлээс үндэстэй бөгөөд Аристотель, хүн зөвхөн үйлдлээ бус, өөрийн хүн чанараа сайжруулах зорилгоор шийдвэр гаргах ёстой гэсэн үндсэн санааг “Никомахын ёс зүй” бүтээлдээ томъёолжээ (Даш-Ёндон.Б, 2011).

Өөрөөр хэлбэл зан байдал, сайн чанарын ёс зүй нь аливаа үйлдлийн зөв, бурууг тухайн хүний зан чанараар дамжуулан үнэлдэг бөгөөд шударга ёс, эр зориг, энэрэл зэрэг ёс суртахууны чанаруудыг хөгжүүлэхийг дэмждэг.

Зан байдал, сайн чанарын ёс зүйн онол нь төрийн албанд ажиллагчдын ёс суртахууны зөв, шударга зан чанарыг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой. Энэхүү онолын үзэл баримтлалын дагуу төрийн албан хаагчид зөвхөн хууль болон дүрэм журамд захирагдахаас гадна хувийн зан төлөв, сайн чанарууд болох шударга, хариуцлагатай, эелдэг, энэрэнгүй байх зэрэгт тулгуурлан өөрийн үйлдлээ удирдах ёстой юм. Ингэж төрийн албан хаагчдын хувийн эерэг чанаруудыг хөгжүүлснээр ёс зүйн зөрчлөөс зайлсхийж, илүү шударга, хариуцлагатай төрийн албаны тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлдэг гэж үздэг. Төрийн албан хаагчдыг ёс зүйн сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамруулж, зан байдалд эерэг хандлагыг төлөвшүүлэх, ёс суртахууны боловсрол олгохыг зорьж байгаа нь энэхүү онол үйлчилж байгаагийн нэг илрэл юм.

Сүүлийн үед ёс зүйн хандлага болоод хувь хүний зан чанарын судалгаанууд төрийн байгууллага дахь ёс зүйг сайжруулахад онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд судлаачдын үзэж байгаагаар зан байдал, сайн чанарт суурилсан ёс зүйн хандлага нь хууль, журмаас хэт хамааралтай хариуцлагын ёс зүйтэй харьцуулахад илүү бодит үр дүнг бий болгодог гэж үздэг ажээ ((MacIntyre, 2007); (Solomon, 1992)).

#### **2. Үр дүнд суурилсан ёс зүйн онол (Consequentialism)**

Үр дүнд суурилсан ёс зүйн онол нь аливаа үйлдлийн ёс зүйтэй эсэхийг үр дагавраар нь дүгнэдэг онол юм. Энэ онолын үндсэн санаа бол үйлдэл нь сайн үр дүн авчрах эсэхээр үйлдлийн зөв, бурууг тодорхойлдог явдал юм. Үр дүнд суурилсан ёс зүйн онолын хамгийн түгээмэл жишээ бол утилитаризм (utilitarianism) бөгөөд энэ нь олонхын аз жаргалыг нэмэгдүүлэхийг ёс суртахууны хамгийн өндөр үнэлэмж гэж үздэг. Жон Стюарт Милл утилитаризмыг хөгжүүлж, хүний сайн сайхныг дээд зэргээр хангах нь ёс зүйтэй үйлдлийн зорилго гэж тодорхойлсон байна (Sandel, 2010). Жишээ нь олон нийтийн сайн сайхны төлөө олонх хүний амьдралыг сайжруулах бодлого, шийдвэр гаргахад уг онолыг ашиглах нь бий. Үүнээс гадна үр дүнд суурилсан онол нь үр дагаврыг тооцохдоо хэнийг эсвэл юуг хамгийн их хохироож эсвэл хамгаалж байгааг ч харгалзан үздэг байна (Driver, 2011).

Харин сул тал нь олонхын сайн сайхныг чухалчлавч цөөнхийн эрх ашгийг орхигдуулчих гээд байдаг талтай (J. J. C. Smart, Bernard Williams, 1973).

Үр дүнд суурилсан онол нь төрийн албаны ёс зүйд шийдвэрийн үр дагаврыг харгалзан ёс зүйн үнэлгээ өгөх, шийдвэр гаргах арга замыг санал болгодог. Үйлдлийн зөв эсэхийг үр дүнгээр нь тодорхойлдог энэ онолын зарчим нь төрийн албан хаагчдын хувьд аливаа шийдвэрийн эцсийн үр дүн, үр ашигт анхаарал хандуулахад хүргэдэг байна. Төрийн албаны ёс зүй дэх үр дүнд суурилсан ёс зүйн онолын хэрэглээ нь дараах байдлаар илэрдэг байна. Үүнд:

- **Хамгийн их ашигтай үр дүнг эрэлхийлэх.** Үр дүнд суурилсан онол нь төрийн албан хаагчдын аливаа үйл ажиллагаа нь иргэдэд хамгийн их ашиг тус хүргэх эсэхийг харгалзан үзэхэд чиглүүлдэг. Энэ зарчмын дагуу төрийн байгууллагуудын бодлого, хөтөлбөрүүд нь нийт нийгэмд хамгийн их эерэг үр нөлөө үзүүлэх ёстой. Жишээлбэл, төрийн албан хаагчид хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хуваарилахдаа иргэдийн хэрэгцээ шаардлагад хамгийн ихээр нийцсэн, эерэг үр дагавар үүсгэх боломжтой хувилбарыг сонгодог (Mill, 1879).

- **Хор уршиг багатай, сөрөг үр дагавар багатай шийдвэр гаргах.** Үр дүнд суурилсан ёс зүй нь төрийн албан хаагчдаас сөрөг үр дагавар үүсгэх боломжтой үйлдлээс зайлсхийхийг шаарддаг. Тухайлбал, төсөл, бодлогын шийдвэр нь тухайн нийгэмд урт хугацааны хор уршиг авчрахгүй байх зарчмыг баримталдаг. Энэ нь нийт иргэдэд нөлөөлөх сөрөг нөлөөг багасгахын тулд ашиг сонирхлын зөрчил, зардал - үр ашгийн үнэлгээ хийх хэрэгцээг бий болгодог байна (J. J. C. Smart, Bernard Williams, 1973).

- **Бодит үр дүнг хэмжих шаардлага.** Үр дүнд суурилсан ёс зүй нь төрийн байгууллагуудад бодлого, шийдвэрийн үр дүнг үнэлж хэмжих соёлыг түгээхэд нөлөөлдөг. Энэ нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, олон нийтэд тайлагнах шаардлагыг бий болгож, ил тод байдлыг хангахад тусалдаг. Тухайлбал, төрийн байгууллагуудын олон нийтэд үзүүлэх үйлчилгээний чанарыг судлах, иргэдийн сэтгэл ханамжийг хэмжих зэрэг үр дүнгийн үнэлгээ хийх хэрэгцээ үүсдэг (Pettit, 2004).

### **3. Үүрэгт суурилсан ёс зүйн онол (Deontology)**

Үүрэгт суурилсан ёс зүйн онол нь аливаа үйлдэл зөвхөн үр дүнгээрээ биш харин үйлдлийнхээ ёс зүйн үүрэг, хэм хэмжээгээр зөв эсвэл буруу гэж тодорхойлогдох ёстой гэж үздэг (Korsgaard, Kant: Groundwork of the Metaphysics of Morals, 2012). Энэхүү онолыг Германы философич Иммануэль Кант хамгийн ихээр

дэмжиж, хөгжүүлсэн бөгөөд ёс зүйн шийдвэр гаргахдаа дүрэм, үүрэг хариуцлагыг баримтлахыг чухалчилдаг.

Үүрэгт суурилсан ёс зүйн онол нь хүний зан үйлийг зөв буруу гэж дүгнэхдээ үр дагавар бус, тухайн зан үйл өөрөө ёс зүйн үүрэгт нийцэж буй эсэхийг анхаардаг. Тиймээс, үр дүнд ямар нэгэн сайн сайхан зүйл гарах эсэхээс үл хамааран үүргээ биелүүлэх нь хүний ёс зүйн хэм хэмжээнд чухал байр суурь эзэлдэг (Korsgaard, Kant: Groundwork of the Metaphysics of Morals, 2012). Үүрэгт суурилсан ёс зүйн онол нь эрх чөлөө, хүний эрхийг хамгаалах, шударга ёс тогтоох зэрэг зарчмуудыг бататгахад ач холбогдолтой. Хүн төрөлхтөн ёс суртахуунтай амьдрахдаа зөвхөн сайн үр дүнг харж үйлдэх бус, ёс зүйн зарчим, үүрэг хариуцлагаа биелүүлснээр иргэний болон төрийн байгууллагын ёс зүйг хангаж байдаг (Korsgaard C. M., 1996).

Үүрэгт суурилсан ёс зүйн онол нь төрийн албан хаагчдыг үр дүн бус үүрэг, зарчимд суурилан үйл ажиллагаагаа явуулахыг шаарддаг тул тэдний өдөр тутмын шийдвэр гаргалт, зан байдалд ёс зүйн стандарт, хэм хэмжээг сахихад чиглүүлдэг. Үүрэгт суурилсан ёс зүйн хүрээнд төрийн албан хаагчид шударга, үнэнч, хариуцлагатай байхыг шаарддаг бөгөөд үүнд тэдний үйл ажиллагаа нь зөвхөн үр дүнг харгалзах бус, хууль, дүрэм журамд нийцсэн байх ёстойг онцолдог.

#### **4. Нийгмийн гэрээний онол (Social Contract Theory)**

Нийгмийн гэрээний онол (Social Contract Theory) нь төр, нийгмийн харилцаа, ёс суртахууны үндсийг тайлбарладаг бөгөөд энэ онолын гол санаа нь хүмүүс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд эрх, үүргээ хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулан хамтран амьдрах хүсэлтэй байдгийг онцолдог. Үүний дагуу иргэд өөрийн эрхийн тодорхой хэсгийг төрд шилжүүлснээр тухайн нийгэмд хамгаалагдсан, аюулгүй орчин бий болдог гэж үздэг. Энэ онол нь орчин үеийн улс төрийн философи, ёс зүйн суурь онолуудын нэг бөгөөд Томас Хоббс, Жон Локк, Жан-Жак Руссо нарын бүтээлүүдэд тусгалаа олсон байдаг.

Орчин үед Жон Роулс нарын философичид энэхүү онолыг улам хөгжүүлэн тэгш эрх, шударга ёсны зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар судалсан байдаг. Роулсын “A Theory of Justice” (1971) бүтээлд нийгмийн гэрээний үндсийг шударга ёс, тэгш байдалд тулгуурлан шинээр тайлбарлаж, ёс зүйн хүрээнд нийгмийн шударга ёсны зарчмыг тогтоох талаар тодорхойлсон (Rawls, 1971).

Нийгмийн гэрээний онол нь төрийн албаны ёс зүйд хэрэглэгдэхдээ төрийн албан хаагчид ба төрийн хоорондын харилцааг зохицуулах, тэдгээрийн үүрэг, ёс суртахуунтай байдал, иргэдийн итгэл найдварыг хангах суурь зарчим болдог. Энэ онол нь төрийн албан хаагчдыг нийтийн сайн сайхны төлөө ажиллах үүрэг хариуцлагатай болгож, өөрсдийн үйл ажиллагааг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэх шаардлагатайг онцолдог.

Нийгмийн гэрээний онол нь төрийн албаны ёс зүйд дараах байдлаар хэрэглэгддэг байна. Үүнд:

- **Иргэдтэй итгэлцэл тогтоох.** Нийгмийн гэрээний онолын зарчмууд нь төрийн албан хаагчдыг иргэдийн итгэлийг хүлээж ажиллах, тэдэнд шударга, ил тод хандахыг шаарддаг. Энэ нь ард иргэд, төрийн албан хаагчдын хооронд итгэлцэл бий болгож, төрийн албаны шударга ёсыг бататгах үндэс болдог. Жон Роулс (1971) шударга ёсны онолдоо иргэдийн итгэлийг олж авахад ёс суртахууны үндэс хэрэгтэйг онцолсон байдаг.

- **Төрийн албаны үүрэг хариуцлагын үндэс.** Нийгмийн гэрээний онолын дагуу төрийн албан хаагчид иргэдийн итгэлийг хүлээсэн байдлаар нийтийн сайн сайхны төлөө ажиллах ёстой гэж үздэг. Хоббс (1651), Локк (1689), Руссо (1762) нарын тайлбарласнаар төрийг байгуулсан нь иргэдийн аюулгүй байдал, эрх чөлөөг хамгаалахын тулд иргэд төрд зарим эрхээ шилжүүлсэнтэй холбоотой.

- **Ёс зүйтэй байх шаардлага.** Төрийн албан хаагчдын хувьд иргэдтэй байгуулсан “гэрээ” буюу төрийн албан ёсны үүргийг ёс суртахуунтайгаар гүйцэтгэх шаардлага үүсдэг. Энэхүү шаардлага нь албан тушаалтнуудын хувьд нийгэмд хүлээсэн хариуцлага, шударга ёс, нээлттэй байдал зэрэгт үндэслэнэ.

- **Төрийн хяналт, зохицуулалт.** Нийгмийн гэрээний онол нь төрийн албанд хяналт тавих, ёс зүйн дүрэм журам боловсруулж, хэрэгжүүлэх үндсийг тодорхойлдог. Жишээ нь Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудад төрийн албан хаагчид иргэдийн итгэлийг хүлээж ажиллах ёстойг тусгасан байдаг нь нийгмийн гэрээний онолын хэрэглээний нэг жишээ юм.

## **5. Эрхэд суурилсан ёс зүйн онол (Rights-based Ethics)**

Эрхэд суурилсан ёс зүйн онол нь хүн бүрийн суурь эрхийг хамгаалах ёстой гэсэн үндсэн зарчимд тулгуурладаг. Энэ онол ёсоор хүний эрхийг ёс зүйн шийдвэр гаргалтад тэргүүлэх байр суурьтай гэж үздэг бөгөөд хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэхийг чухалчилдаг байна. Эрхэд суурилсан ёс зүйн онолын дагуу ёс суртахуунтай байх гэдэг нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах гэсэн утга санааг агуулдаг.

Эрхэд суурилсан ёс зүйн онолыг Жон Локк, Иммануэл Кант нарын философичид хөгжүүлсэн. Жон Локк хүн бүрт заяагдмал, төрөөс хамааралгүй эрхүүд бий гэж үзсэн бөгөөд амьд явах эрх, эрх чөлөө, өмчтэй байх эрхийг (Locke, 1689) тэрхүү анхдагч, заяагдмал эрх гэж нэрлэсэн байдаг. Иммануэл Кантын хувьд хүнийг зорилготой оршихуй гэж үзсэн бөгөөд хүн бүрийн хувийн эрхийг хүндэтгэх ёстой гэсэн үзлийг дэвшүүлсэн байдаг (Korsgaard, Kant: Groundwork of the Metaphysics of Morals, 2012).

Энэхүү онол нь хүмүүсийг төрийн, нийгмийн болон хувийн харилцаанд шударга ёсыг эрхэмлэх, эрх зүйн хүрээнд харилцан эрхээ хүндэтгэх зарчмыг үндэслэж байгаа юм.

Эрхэд суурилсан ёс зүйн онол нь төрийн албан хаагчдад тодорхой үүрэг хариуцлагыг оноодог. Тухайлбал, төрийн албан хаагчид хүний эрхийг зөрчихгүй, хууль ёсыг сахин биелүүлэх замаар иргэдийн суурь, заяагдмал эрхийг хангах үүрэгтэй. Төрийн албаны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад эрх зүйн заалтуудыг даган мөрдөхөөс гадна иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах ёстой гэж үздэг (Donnelly, 2013) байна.

Эрхэд суурилсан ёс зүйн онол нь ёс зүйн шийдвэр гаргалтад хүний суурь эрхийг харгалзан үзэх, бодлого боловсруулахад шаардлагатай онолын үндэс суурь болдог.

Ийнхүү ёс зүйн сонгодог онолууд нь төрийн албаны ёс зүйд өөр өөрийн гэсэн үүргээ гүйцэтгэж, хувь нэмрээ оруулж байна. Тухайлбал,

**Шударга, ил тод засаглал бий болгох:** Ёс зүйн сонгодог онолуудыг хэрэглэх нь төрийн албан хаагчдад шударга, ил тод үйл ажиллагаа явуулахад тус дэм болдог. Үр дүнд суурилсан ёс зүйн онол нь төрийн шийдвэрүүдийн үр дүнг олон

нийтийн сайн сайхны төлөө чиглүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа бол үүрэгт суурилсан ёс зүй нь төрийн албан хаагчдыг хууль ёсны үүргээ биелүүлэхэд тусалдаг. Энэ нь төрийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлж, тэдний өмнө төрийн албан хаагчдын хүлээх хариуцлагыг дээшлүүлдэг байна.

**Төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг бататгах:** Зан байдал, сайн чанарын ёс зүй нь төрийн албан хаагчдын ёс суртахууны төлөвшил, хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн албан хаагчид зөвхөн хууль бус шийдвэр гаргахгүй байх бус, шударга ёсыг сахих, бусдыг хүндэтгэх, хариуцлага хүлээх чадвартай байх ёстой. Энэ онол нь албан хаагчдыг ёс зүйн зөв хандлагатай, мэдлэг чадвартай байхыг дэмждэг.

**Иргэдийн эрхийг хамгаалах, шударга шийдвэр гаргах:** Нийгмийн гэрээний онол нь төрийн эрх мэдэл нь иргэдээс олгосон зөвшөөрөлд үндэслэдэг гэдгийг онцолж, төрийн албан хаагчдыг иргэдийн эрхийг хамгаалах үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрдөг. Эрхэд суурилсан ёс зүйн онол нь төрийн албан хаагчдыг хүний суурь эрхийг хүндэтгэсэн шийдвэр гаргах ёстой болохыг чухалчилдаг.

**Нийгэмд зөв хэвшил, ёс суртахуун хөгжүүлэх:** Төрийн албан хаагчдын ёс зүй нь зөвхөн байгууллагын дотоодод төдийгүй нийгэмд ч нөлөөлдөг. Ёс зүйн сонгодог онолуудыг хэрэглэх нь төрийн албан хаагчдыг зөв үлгэр дуурайл, манлайллыг үзүүлж, нийгэмд эерэг өөрчлөлтүүд авчрахад нөлөөлдөг байна.


Эцэст нь дээрх ёс зүйн онолууд нь төрийн албаны үйл ажиллагаанд ёс зүйн өндөр шаардлага, стандартыг тогтоож, улмаар төрийн албанд баримтлах ёс зүйн хэм хэмжээний үндсийг тодорхойлох, төрийн үйлчилгээг тэгш, шударга хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улмаар төрийн бодлого, үйл ажиллагаанд итгэх иргэд, олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Зураг 21. Ёс зүйн зан төлөвийг сайжруулах чиг хандлага, арга зам



Эдгээр чиг хандлагууд нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйт соёлыг төлөвшүүлэх, байгууллагын болон хувь хүний зан төлөвийг сайжруулахад онол, практикийн чухал ач холбогдолтой бөгөөд судалгаануудаас харвал ёс зүйн зөрчлийн үндсэн шалтгааны нийтлэг 9 хүчин зүйлсийг тодорхойлсон.

Зураг 22. Ёс зүйн зөрчлийн нийтлэг шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс



## ДӨРӨВ. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4.1. Ёс зүйн хорооны бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт зааснаар Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Л.Цэдэвсүрэн, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, Б.Пүрэвдагва нар албан тушаалаар, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор Ш.Батсүх (Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн, Доктор /Sc.D/, профессор, Монгол Улсын гавьяат багш), Ч.Эрдэнэчимэг (Удирдлагын академийн багш, Доктор /Ph.D/), М.Цэрэнбат (Анагаахын шинжлэх ухааны Үндэсний их сургуулийн багш, Доктор /Ph.D/, дэд профессор) нар, Улсын Их Хурлын Байнгын Хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Д.Дуламсүрэн (Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар) нарыг тус тус Ёс зүйн хорооны гишүүнээр томилсноор 9 гишүүн бүрэн бүрэлдэхүүнтэй чиг үүргээ хэрэгжүүлж эхэлсэн.

Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн анхны хуралдааны 03 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсийг Ёс зүйн хорооны даргаар томилсон.

Зураг 23. Ёс зүйн хорооны бүтцийн бүдүүвч



Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг "Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна" гэж заасны дагуу мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд Ёс зүйн хороо нь нийт 17 удаа хуралдаж 51 асуудлыг хэлэлцэн 15 тогтоол шийдвэр гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. /Нийт 72 цаг хуралдаж, нэг удаагийн хуралдаан дунджаар 4.2 цаг үргэлжлэн, 1 асуудалд дунджаар 1.4 цагийг зарцуулсан байна.

Хүснэгт 5. Ёс зүйн хорооны хуралдааны тойм

Д/д	Хуралдааны тоо	Хэлэлцсэн асуудлын тоо	Хуралдсан цаг, минут	1 хуралдааны үргэлжлэх дундаж хугацаа	1 асуудалд зарцуулсан дундаж хугацаа
1	17	51	72 цаг	4.2 цаг	1.4 цаг


Зураг 24. Хуралдаанд хэлэлцсэн асуудал 2024 он /нийт- 51/



Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу 164 мэдээг хуулийн хугацаанд байршуулж, нийт 209 мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод болгов.

Ёс зүйн хорооны 81 тушаалаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр Ёс зүйн хорооны даргын 17, Ажлын албаны даргын 32, хүний нөөцийн чиглэлээр Ёс зүйн хорооны даргын 8, Ажлын албаны даргын 24 тушаал батлагдсан байна.

Зураг 25. Ирсэн өргөдөл, гомдол, хүсэлт



Ёс зүйн хороонд нийт 60 өргөдөл, гомдол ирснээс хүний нөөцтэй холбоотой 14 хүсэлт, 6 өргөдлийг хууль, журмын дагуу шийдвэрлэж, 34 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, хугацаа болоогүй судлагдаж байгаа 6 гомдол байна.

#### 4.2 Гадаад хамтын ажиллагаа

Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын орчинд шинэлэг арга, технологи нэвтрүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн индекс, стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах чиглэлээр гадаад улс орнуудын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг тогтоох чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчидтэй хамтран ажиллаж байна.

Монгол Улсад суугаа элчин сайд нар, олон улсын байгууллагуудын суурин

төлөөлөгчдөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль эрх зүйн орчин, Ёс зүйн хорооны чиг үүрэг, эрхлэх асуудал, төрийн албаны шинэтгэлийн явцын талаар товч танилцуулж, ёс зүйт төрийн албыг төлөвшүүлэх, хөгжингүй орнуудын туршлага, хамтын




ажиллагааны чиглэлээр санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг Төрийн албаны зөвлөл болон Гадаад харилцааны яамтай хамтран зохион байгуулав. Уулзалт хэлэлцүүлгийн мөрөөр Ёс зүйн хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамтын ажиллагааг шинээр тогтоох, улмаар түүнийг өргөжүүлэх чиглэлд санал солилцох уулзалтуудыг эхлүүллээ. Тухайлбал, БНСУ-тай төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сургалт, соён гэгээрүүлэх, зөөлөн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр, төрийн албан хаагчийн ёс зүйг төлөвшүүлэх



чиглэлээр; Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай цахим сургалтын баазыг бий болгох, хөгжүүлэх, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн агуулгад ёс зүйн асуудлыг тусгах, шинээр ажлын байранд бэлтгэгдэж буй залуучуудад чиглэсэн сургалтын хөтөлбөр бий болгох талаар; Дэлхийн Банктай сайн засаглалыг бэхжүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд түншлэгч талууд, хамтран ажиллах байгууллагыг судлан, дэмжлэг үзүүлэх; Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагат ёс зүйн чиглэлээр сургагч багш бэлтгэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажилд дэвшилтэт арга хэлбэрийг ашиглан хөгжүүлэх, түгээх, төрийн албан хаагчийн ёс зүйн индексийг нэвтрүүлэх ажилд хамтрахаар тус тус ажил хэргийн хүрээнд уулзав. Эдгээр ажил нь Монгол Улсын төрийн албыг олон улсад үнэлэгдэхүйц болгох, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх, хэм хэмжээг сахиулах бодлого, үйл ажиллагааг шинэ шатанд гаргахад тодорхой хувь нэмэр боллоо.

Түүнчлэн Ёс зүйн хорооны гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, өмнө гаргасан хүчин чармайлтаа бататгах хүрээнд Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс Канад болон Америкийн Нэгдсэн Улсад, гишүүн Б.Идэрчулуун Швейцарын Холбооны Улсад, гишүүн Б.Пүрэвдагва Бүгд Найрамдах Турк Улсад тус тус томилолтоор ажиллав. Дээрх 2 улсын албаны хүмүүстэй төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албаны хүний нөөцийг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын орчинд шинэлэг арга, технологи нэвтрүүлэх, хэлбэрт сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн индекс, стандарт, ёс зүйн дүрмийг мөрдүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, ёс зүйн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах чиглэлд хамтран ажиллах хүсэлтийг тавьж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах зэрэг олон талт санал солилцлоо.



Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлэхийн зэрэгцээ өөрийн орны төрийн болон нийтийн байгууллагуудтай төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг таниулах нөлөөллийн аяныг зохион байгуулах, нийгэмд ёс зүй, ёс суртахууны эерэг чиг хандлагыг бий болгох чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүд, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Батлан хамгаалах яамны холбогдох хүмүүстэй уулзалт, ярилцлагыг тус тус зохион байгуулж, цаашид хамтран ажиллах санал, чиглэлийг тогтлоо.



## **ДҮГНЭЛТ**

Улсын Их Хурлаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ батлагдаж, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо бүрдэж байна. Энэ ёс зүй хариуцлагын тогтолцоо бүрэлдсэнтэй холбоотойгоор иргэд, олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага сайжирч, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөө дээшилнэ гэсэн хүлээлт бий болсон нь судалгааны дүнгээс харагдаж байна.

2024 оны III улирлын байдлаар 4239 төрийн байгууллагын 2281 ёс зүйн дэд хороо байгуулагдсан нь нийт төрийн байгууллагын 53.8 хувь нь ёс зүйн дэд хороо байгуулжээ. 2281 ёс зүйн дэд хороодыг төрийн байгууллаар задалж үзэхэд УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллага, тэдгээрийн салбар байгууллагын 19.6 хувь, Засгийн газрын харьяа байгууллагуудын 55.4 хувь, нутгийн өөрөө удирдах байгууллагын 5.2 хувь нь тус тус ёс зүйн дэд хороо байгуулсан байхад шүүх эрх мэдлийн байгууллага 100.0 хувь ёс зүйн дэд хороо байгуулж, үйл ажиллагаагаа тайлагнан ажиллаж байна.

Ялангуяа нийт төрийн албан хаагчдын 96.0 хувь нь Засгийн газар харьяа төрийн төв байгууллага, түүний харьяа газар, хэлтсүүд ажиллаж байгаа бөгөөд ёс зүйн дэд хороог байгуулах, орон тооны болгох, чадавхжуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Иймээс төрийн албаны ёс зүйн манлайллыг үлгэрлэн үзүүлэх ёстой төрийн төв байгууллагууд, түүний харьяа газар, хэлтсүүд ёс зүйн дэд хороогоо бүрэн байгуулах, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төсөв, хуульд заасан урамшуулал олгох асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Төрийн албан хаагчийн ёс зүй, тэднийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, иргэд, олон нийтийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд 4239 төрийн байгууллага дахь Ёс зүйн дэд хороод онцгой үүрэгтэй байна.

